



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АРВАН ДӨРӨВ ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 10

Мөрөн сум

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48,1 дэх хэсгийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арвандөрөвдүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Бэлчээр ашиглуулах журам батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дүгээр сарын 23 ны өдрийн 04 дугаар тогтоол нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй учир тухайн тогтоолыг хүчингүйд тооцсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (Б.Баянсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХСҮХ